

БАРИВЧЛАХ ШИЙТГЭЛИЙН ТАЛААРХ ШҮҮХИЙН ШИЙДВЭР, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

COURT'S DECISION ON ARREST SENTENCE AND ANALYSIS OF ITS RESULTS



Д.Чинзориг

*Дотоод хэргийн их сургуулийн докторант,
хурандаа*

Товч утга: Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны үндсэн нэг чиглэл нь зөрчил гаргасан этгээдэд оногдуулсан баривчлах шийтгэлийг эдлүүлэх явдал бөгөөд энэхүү шийтгэлийн агуулга нь зөрчил үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлан тодорхой нөхцөл, журам бүхий байранд саатуулахад оршдог. Хэдийгээр энэ шийтгэл нь нийгмээс тусгаарлах агуулгатай ч тухайн зөрчил гаргасан этгээдийн зан үйлд нөлөөлөх сургалтыг олон талт хэлбэрээр зохион байгуулж, эерэг нөлөөлөл үзүүлэхэд чиглэгдсэн байдгаараа онцлогтой. Иймд баривчлах шийтгэлийн бодлогыг нийгэм, хувь хүнд өгөөжтэй байдлаар хэрэгжүүлэх нь зүйтэй болно.

Энэхүү өгүүлэлд Монгол Улсын хэмжээнд баривчлах шийтгэл эдлүүлэх ажиллагааны чиглэлээр батлан гаргасан эрх зүйн эх сурвалжуудад анализ хийхээс гадна баривчлах шийтгэлийн хэрэгжилт, үр дүнгийн талаар дүн шинжилгээ хийж, тоймлон авч үзэв.

Түлхүүр үгс: зөрчил, баривчлах шийтгэл, албадлагын арга хэмжээ, эрх зүйн зохицуулалт, албадан сургалт.

Abstract: One of the main areas of activity of the Mongolian Court Enforcement Organization is to serve the punishment of arrest imposed on the person who committed the violation. Although this punishment has the content of isolation from society, it is characterized by the fact that training to influence the behavior of the person who committed the violation is organized in a multifaceted manner and aimed at having a positive impact. Therefore, it is desirable to implement the detention policy in a way that benefits society and individuals.

In this article, in addition to the analysis of the legal sources adopted in the field of arrest punishment throughout Mongolia, the implementation and results of arrest punishment were analyzed and reviewed.

Keywords: violations, arrests, coercive measures, legal regulation and compulsory training.

Гэмт хэрэг, зөрчил ба түүнд оногдуулах ял, шийтгэлийн талаарх бодлого шинэчлэгдэн хөгжихтэй зэрэгцэн түүнийг хэрхэн гүйцэтгэх, хэрэгжүүлэх ажиллагаа ч мөн адил түүхийн цаг хугацааны явцад өөрийн гэсэн зүй тогтлоо даган хэлбэршиж хууль зүйн шинжлэх ухааны бие даасан салбар болон хөгжиж иржээ. Улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л салбарууд, тэр дундаа хууль сахиулах салбарт хийгдэж буй тогтолцооны болон эрх зүйн шинэчлэл, өөрчлөлтүүд нь хүний хөгжлийг, улмаар нийгмийн зөв тогтолцоог дэмжин хөгжүүлэхэд чиглэгдсэн байх ёстойг салбарын эрдэмтэд хүлээн зөвшөөрч байна.

Төрийн үндсэн чиг үүргийн нэг нь иргэдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж хамгаалах, хууль зөрчигчдөд хариуцлага тооцох, хэрэг маргааныг таслан шүүх замаар нийгэмд шударга ёс, дэг журмыг тогтооход оршдог. Тиймээс зөвхөн хууль, шүүх эрх мэдлийн байгууллагууд төдийгүй төр, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагаа нь гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд чиглэх нь нь ач холбогдолтой байна.

Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 11-ны өдөр батлан гаргаж, мөн оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 2.1 дүгээр зүйлд “хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэнэ” гэж заасан ба “Хууль зөрчих” гэж хууль, Захиргааны ерөнхий хууль, бусад хуульд заасан журмын дагуу хүчин төгөлдөр болсон захиргааны хэм хэмжээний акт зөрчсөнийг ойлгогдохоор байна.

Зөрчлийн эрх зүй нь дан ганц судлагдахуун болоод зогсохгүй улс үндэсний эрх зүйн тогтолцооны шинэчлэл, өөрчлөлтийн асуудал мөн бөгөөд оновчтой хууль зүйн зохицуулалт, онол, арга зүй, практик хэрэглээг хослуулахгүй бол эрх зүйн маргаан дагуулах, улмаар тогтолцооны хувьд гажуудал үүсгэж болохуйц асуудал учраас зөрчил, түүний агуулга, динамик шинж, түүнээс үүдэн гарах үр дагавар, улмаар оногдуулах шийтгэлийг судлах нь нэн чухал юм.

Бидний уламжлалт ойлголтоор “захиргааны зөрчил” хэмээх ухагдахуун нь өдгөө “зөрчил” гэсэн нэршлээр шинжлэх ухааны эргэлтэд орж, онол ба практикт хэдий танигдсан боловч түүний судлагдсан байдал нь төдийлөн хангалттай бус, үндэсний болон олон улсын эрх зүйн асуудлыг цогцоор авч үзэх, практикт тулгамдаж буй асуудлыг шинжлэн судлах нь тулгамдаж буй асуудлын нэг гэж үзэж болно.

Эрх зүйн онолын талаас нь “Зөрчил” гэх ойлголтыг хууль зүйн доктор, дэд профессор Ч.Нямсүрэн “Эрх зүйн зөрчил гэж эрх зүйн хэм хэмжээний шаардлагыг зөрчсөн буюу түүний эсрэг чиглэсэн, нийгэмд хор аюултай, хуульд зааснаар хүлээх тусгай хариуцлага хүлээх эрх зүйн чадамжтай этгээдийн зан үйл” хэмээн бүтээлдээ¹ тэмдэглэжээ. Тиймээс захиргааны зөрчил нь захиргааны журам зөрчсөнөөс үүдэн гардаг². Нийтээр дагаж мөрдүүлэхээр тогтоосон зан үйлийн горим, эрх зүйн хэм хэмжээг захиргааны журам гэнэ³. Захиргааны хариуцлага хүлээлгэх бодит үндэслэл нь захиргааны зөрчил гаргасан явдал юм. Мөн эрх зүйн зөрчлийг *гэмт хэрэг, захиргааны эрх зүйн зөрчил, иргэний эрх зүйн зөрчил, сахилгын зөрчил, олон улсын эрх зүйн зөрчил* гэсэн төрлүүдтэй хэмээн үзжээ.

Зөрчил болон гэмт хэргийн хоорондын ялгаатай шинжийн асуудал нь судлаачдын заавал хөндөх чухал сэдвийн нэг юм. Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хууль тогтоомжийн уялдаа холбооны нэг чухал асуудал бол гэмт хэрэг, зөрчил нь нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээгээрээ ялгагдах хэдий боловч харилцан бие биенийгээ нөхөх замаар хоорондоо харилцан нөхцөлдсөн байдаг явдал юм. Учир нь гэмт хэргийн нийгэмд аюултай шинж нь байнга хувьсан өөрчлөгдөж байдаг ойлголт бөгөөд үүнтэй холбоотойгоор Монгол Улсын Эрүүгийн хуулийн 2.1 дүгээр зүйлийн 3-т “Энэ хуулийн тусгай ангид заагаагүй үйлдэл, эс үйлдэхүй, хохирол, хор уршиг, гэм буруугийн шинжийг төсөөтэй хэрэглэж гэмт хэрэгт тооцохгүй” гэсэн заалт нь гэмт хэрэг, зөрчлийн ялгааг хуульчилсан нийтлэг хэм хэмжээ болох юм.

Зөрчлийн хууль ба захиргааны хариуцлагын хэм хэмжээ тогтоосон бусад хууль тогтоомжийн заалтыг үзэхэд гэмт хэрэг, захиргааны зөрчлийн ялгааг “... хэрэв эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол” гэсэн ерөнхий үг хэллэгээр заагласан нь бий.

¹ Ч.Нямсүрэн, “Эрх зүйн онол” ерөнхий анги, УБ., 2016, 385 дахь тал.

² Ж.Сүхбаатар, “Захиргааны эрх зүй”, УБ., 2005, 35 дахь тал.

³ Мөн тэнд

Зөрчил нь *эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн байх; нийгэмд хор уришигтай байх; гэм буруутай үйл ажиллагаа байх; хууль тогтоомжид заасан шийтгэл хүлээх үйлдэл, эс үйлдэл* гэсэн хууль зүйн шинжийг агуулдаг бөгөөд зөрчил гаргасан этгээдэд торгох; тусгайлан олгосон эрх хасах; хууль бусаар олсон орлого, эд зүйл буюу зөрчил гаргахад ашигласан тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, байрыг хураах; **баривчлах** шийтгэл оногдуулахаар заасан бөгөөд торгох, баривчлах шийтгэлийг шийтгэлийн үндсэн хэлбэрээр хэрэглэхээр хуульчилсан юм.

Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь (*Нарангэрэл.С, 2021*)-д *баривчлах* гэдэг нь (*лат. arrestium; анг. arrest; detention*) 2002 оны ЭБШХуулиар сэжигтэнд хэрэглэдэг байсан байцаан шийтгэх албадлагын арга хэмжээ, мөн оны Эрүүгийн хуульд үндсэн ялын нэгэн төрөл, Цэрэг ба дотоод хэргийн байгууллагын сахилгын дүрэмд заасан сахилгын шийтгэлийн арга хэмжээ, зарим улсын эрүүгийн процессын эрх зүйд яллагдагчийг цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ, Монгол улсын хууль тогтоомжоор захиргааны шийтгэлийн хамгийн хатуу арга хэмжээ болж байв гэж тайлбарлажээ.

Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн тайлбар толь (*Бадам.Д, 2009*)-д баривчлах нь Эрүүгийн хэргийг мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаанд яллагдагч буюу шүүгдэгчийг хуульд заасан тодорхой үндэслэлээр прокурорын зөвшөөрөлтэйгөөр шүүхийн шийдвэрийн дагуу тусгаарлахыг хэлнэ гэж тодорхойлсон бөгөөд Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны албадлагын арга хэмжээний нэг төрөлд бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэхээс ноцтой зайлсхийсэн ялтныг дээрх үндэслэл журмын дагуу баривчилж, албадан саатуулж болно гэжээ.

Өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиар Баривчлах шийтгэл нь зөрчил үйлдсэн хүнийг долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар тусгай зориулалтын байранд саатуулах хэлбэрээр хэрэгждэг бөгөөд баривчлах шийтгэлийг шүүгч ногдуулахаар хуульчилж, танхайрах, согтуурах, галт зэвсэг болон амьсгал боогдуулах, нулимс асгаруулах бодис хууль бусаар олж авах, авч явах, хадгалах, хүйтэн зэвсэг хууль бусаар авч явах, албан дайчилгаанаас зайлсхийх зөрчил гаргасан иргэнд баривчлах шийтгэлийг сумын Засаг дарга ногдуулж болно гэж заасан онцлогтой юм.

Өөрөөр хэлбэл, Зөрчлийн хуульд заасан шийтгэл, албадлагын арга хэмжээний нэг төрөл нь *“баривчлах шийтгэл”* бөгөөд энэхүү шийтгэлийн агуулга нь зөрчил үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлан тодорхой нөхцөл,

журам бүхий байранд саатуулахад оршино. Энэ шийтгэл нь нийгмээс тусгаарлах агуулгатай ч тухайн зөрчил гаргасан этгээдийн зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион байгуулж, эерэг нөлөөлөл үзүүлэхэд чиглэгдсэн байдгаараа онцлог учраас онол, практик, эрх зүйн зохицуулалтын онцлогийг шинжлэх ухааны үүднээс судлах шаардлагатай байна.

Мөн баривчлах шийтгэл эдлүүлэх журмыг хуулиар тогтооно гэж заасан хэдий ч бие даасан хуульгүй, өнөөдрийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Баривчлах шийдвэр биелүүлэх журмаар зохицуулж байгаа нь судлагдахууны хүрээг өргөжүүлж, эрх зүйн бие даасан зохицуулалт шаардлагатай байгааг харуулж байна.

Монгол Улсад үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн тоо буурахгүй, жил бүр өсөх хандлагатай байгаа ба Шүүхээс сүүлийн 15 жилийн байдлаар шийдвэрлэсэн захиргааны зөрчлийг судлан үзвэл жилд дунджаар 10.000-20.000 орчим хэргийг шийдвэрлэж, 6000-8000 орчим хүнд баривчлах шийтгэл ногдуулдаг байна.

ШШГЕГ-ын харьяа Баривчлах шийтгэлийг хэрэгжүүлэх нэгжид жилд 4000-7000 хүнд дээрх шийтгэлийг эдлүүлж байгаа ба баривчлагдсан этгээдийн үйлдсэн зөрчлийг ангилан үзвэл 75 орчим хувь нь гэр бүлийн хүчирхийлэл, 10 орчим хувь нь тээврийн хэрэгсэл согтуугаар жолоодох, хүүхдийн эрх зөрчих, мансуурах зэрэг зөрчлийг үйлдсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төв, Баривчлах байр нь төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч субъект болохын хувьд холбогдох хууль тогтоомжийн дагуу баривчлах шийтгэлийн талаарх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх явцдаа зөрчил үйлдэж, баривчлах шийтгэл эдэлж байгаа этгээдийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулахыг үүргийг хүлээдэг. Үүнээс үзвэл нэг талаас Баривчлах төв, байр нь төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч субъект хэдий боловч, нөгөө талаас зөрчил үйлдэгчийн зан үйлийг өөрчлөх, тэдэнд эергээр нөлөөлөх үүргийг хүлээдэг “сургалтын” гэж тодорхойлж болохуйц өвөрмөц чиг үүрэг бүхий байгууллага болох нь харагдаж байна.

Энэхүү байдал ч баривчлах шийтгэл эдлүүлэх ажиллагааны тогтолцоо, зүй тогтол, эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нийгэм, эдийн засаг, эрх зүйн салбарын хөгжил, зөрчлийн динамик шинж, нөхцөл байдалтай холбон өөрчлөх, гадаадын бусад орны ижил чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааны чиг хандлагад нийцүүлэх шаардлагатай байгааг илтгэж байна.

Ялангуяа баривчлагдсан этгээдийг баривчлах шийтгэл эдлүүлэх хугацаанд зан үйлийг өөрчлөх, дахин зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажлын тогтолцоо бүрдээгүй, энэ чиглэлээр олон талт хамтын ажиллагаа дутмаг, зайлшгүй хамтрах байгууллагууд (үүнд нийгмийн анхдагч нэгж гэр бүл ч хамаарна)-ын хэмжээнд эрх зүйн зохицуулалтын хувьд хүлээсэн чиг үүрэг тусгагдаагүй байгаа нь баривчлах шийтгэлийг эдлүүлэх бие даасан эрх зүйн зохицуулалтын болон бүтцийн шинэлэг арга хэлбэр шаардлагатайг мөн харуулж байна.

Эрх зүйн зохицуулалт, хэм хэмжээний хүрээнд үндэсний хууль тогтоомжийг түүхчлэн судалж үзэхэд: Монгол Улсын Засгийн газрын 1923 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 11 дүгээр хурлаар “Цагдан сэргийлэхийн эрх хэмжээний дүрэм”, “Цагдан цээрлүүлснийг зөрчсөнийг яллах хууль”-ийг анх баталж байжээ. Уг хуульд захиргааны журам зөрчсөн, тухайн үедээ эрүүгийн хэргийн шинжгүй зөрчилд арга хэмжээ авах анхны хууль бөгөөд захиргааны зөрчлийн хүнд, хөнгөнийг харгалзан 1-15 хоног хорих, 1-15 төгрөгөөр торгууль ногдуулахаар заасан хэв журам сахиулах, хэрэг зөрчилтэй тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн эрх зүйн акт байсан байна.

Ийнхүү Цагдан сэргийлэх байгууллага анх захиргааны журмаар баривчлах, нийгмээс тодорхой хугацаагаар тусгаарлан шийтгэл оногдуулдаг үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн байна.

Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хууль /1992.11.27/ батлагдан гарах хүртэл захиргааны хариуцлагыг янз бүрийн хууль тогтоомж, эрх зүйн актаар хариуцлага хүлээлгэж байсан ирсэн түүхтэй.

Өнөөгийн Зөрчлийн тухай хууль батлагдахаас өмнө Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй бие даасан 387 хууль байснаас захиргааны хариуцлага ногдуулсан хэм хэмжээ бүхий зүйл, заалттай 177 хуулиас 14 хуульд нь “хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ” гэж ерөнхий байдлаар зааж байсан байна. Захиргааны хариуцлагын тухай хууль нь материаллаг хууль төдийгүй мөн нэг зэрэг процессын хуулийн шинжийг давхар агуулдаг ба 1992 онд батлагдсанаас хойш 1995, 1997, 2004, 2006 онуудад нийт 20 гаруй удаа нэмэлт өөрчлөлт оруулж байсан бөгөөд зарчмын шинжтэй шинэчлэлт огт хийгдээгүй, эрх зүйн зөрчилтэй холбоотой асуудлыг Захиргааны хариуцлагын тухай хуулиар бүрэн зохицуулж чадаагүй, хэм хэмжээний хоорондын зөрчил, давхардал бий болгосон гэж үзэж болно.

Зөрчлийн тухай хууль нь 240 орчим хуулиар хориглож, хязгаарласан 1800 орчим үйлдэл, эс үйлдэхүйг нэгтгэсэн Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон

захиргааны журмыг зөрчсөн тодорхой төрлийн захиргааны зөрчлүүд, тэдгээрийн бүрэлдэхүүн, зөрчил гаргасан этгээдэд хүлээлгэх захиргааны шийтгэлийн төрөл, хэмжээг хуульчилж өгчээ.

2017 оны Зөрчлийн хуульд баривчлах шийтгэл ногдуулахаар заасан 9 зөрчил байх ба эрх зүйн дараах үндсэн зохицуулалттай байна. Үүнд:

- баривчлах шийтгэлийг шүүгч оногдуулна.
- баривчлах шийтгэл эдлүүлэх журмыг хуулиар тогтооно.
- шүүх баривчлах шийтгэлийг жирэмсэн эмэгтэй, арван дөрөв хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэг, эх, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүнд оногдуулахгүй ба энэ тохиолдолд нэг хоногийг арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тооцож торгох шийтгэл оногдуулж болно.
- хуульд заасан тохиолдолд баривчлах шийдвэр биелүүлэхийг хойшлуулж болно.
- зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үед саатуулагдсан хугацааг баривчлах шийтгэл эдлүүлэх хугацаанд оруулан тооцно. Хэд хэдэн зөрчилд оногдуулсан баривчлах шийтгэлийн нийт хугацаа гурван сараас хэтрэхгүй байна.

Зөрчлийн тухай хуулийн 3.1.1-т зааснаар “шийтгэлийн зорилго нь хүн, хуулийн этгээдийг зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, зөрчил үйлдсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх, шударга ёсыг тогтооход оршино” гэжээ.

Хүснэгт 1. 2017 оны Зөрчлийн хуульд баривчлах шийтгэл ногдуулахаар заасан зөрчлийн судалгаа:

д/д	Зөрчлийн хуулийн холбогдох зүйл, заалтын нэр	Агуулга
1.	5.1 дүгээр зүйл.Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах	3.Мансуурсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
2.	5.2 дугаар зүйл.Танхайрах	1.Олон нийтийн газарт, эсхүл орон байранд: 1.1.хэрүүл маргаан үүсгэж; 1.2.бусдыг өдөөн хатгаж; 1.3.бусдын амгалан тайван байдал алдагдуулж; 1.4.олон нийтийг үл хүндэтгэж; 1.5.үйлчилгээний болон дарааллын журам зөрчиж биеэ авч явах нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг зөрчсөн, эсхүл аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,

		эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
3.	5.4 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих	4.Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг: 4.1.зодсон; 4.2.хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан; 4.3.бусадтай харилцахыг хязгаарласан; 4.4.хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
4.	5.8 дугаар зүйл.Жагсаал, цуглаан зохион байгуулах журам зөрчих	6.Жагсаал цуглааныг зохион байгуулагч, оролцогч зэвсэг, хорт бодис, тэсэрч дэлбэрэх бодис, орчин тойрон, хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болохуйц аливаа зүйл, амьтан авч явсан бол зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулах, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
5.	6.20 дугаар зүйл.Хүүхдийн эрхийг зөрчих	6.Тэтгэлэг төлөгч шүүхийн шийдвэрээр сар бүр төлбөл зохих хүүхдийн тэтгэмжийг гурван сараас дээш хугацаанд төлөөгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
6.	6.26 дугаар зүйл.Бэлгийн дарамт учруулах	1.Бусдад ажил, албан тушаал, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгө, сэтгэл санааны үр дагавар үүсгэж бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийх сэдлээ үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

7.	8.6 дугаар зүйл. Хулгайлах	1.Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг албадан сургалтад хамруулж долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
8.	8.7 дугаар зүйл.Хөрөнгө завших	1.Бусдын итгэмжлэн хариуцуулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг завшсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
9.	14.7 дугаар зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих	5.Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

Энэ нь санаатай буюу болгоомжгүй гэсэн хоёр үндсэн хэлбэртэй байна. Эрх зүйн зарим зөрчил нь бэлтгэлт завдалтын үедээ, зарим нь тодорхой бодит хор уршиг учруулснаар төгс үйлдэгдсэнд тооцогдоно. Монгол Улсын хэмжээнд сүүлийн 5 жилд дунджаар 16800 орчим, үүнээс Нийслэл болон Орхон, Өвөрхангай, Төв аймгийн үзүүлэлтүүд бусад аймгаас өндөр үзүүлэлттэй байна.

Хүснэгт 2. Монгол Улсын хэмжээнд 2015-2019 оны хооронд баривчлах шийтгэл оногдуулсан судалгаа¹

д/д	Аймаг	2019	2020	2021	2022	2023 оны I улирал
1.	Архангай	404	400	403	576	113
2.	Баян-Өлгий	265	287	209	479	128
3.	Баянхонгор	395	467	619	677	166
4.	Булган	277	391	425	451	146
5.	Говь-Алтай	185	245	252	361	82
6.	Говьсүмбэр	131	120	189	218	63
7.	Дархан-Уул	317	258	314	421	129
8.	Дорноговь	284	238	249	512	135
9.	Дорнод	311	440	357	440	108

¹ ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны, шинжилгээний газрын тайлан.

10.	Дундговь	112	108	136	185	51
11.	Завхан	288	312	314	392	84
12.	Орхон	922	846	633	723	188
13.	Өвөрхангай	1286	1501	1044	1134	320
14.	Өмнөговь	203	285	348	364	96
15.	Сүхбаатар	160	237	221	284	79
16.	Сэлэнгэ	398	356	433	643	218
17.	Төв	528	521	515	578	118
18.	Увс	251	377	473	442	64
19	Ховд	374	448	383	474	9 3
20 .	Хөвсгөл	326	426	404	508	1 47
21 .	Хэнтий	487	543	444	589	1 25
22 .	Улаанбаатар	7392	8555	6601	9363	2 417
Нийт		1529 6	1736 1	1496 6	1981 4	5 070

Монгол Улсад эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхээс гаргасан шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд биелүүлж байгаа ба эрх зүйн болон үйл ажиллагааны шинжилгээний хүрээнд дараах дүгнэлтийг хийж байна.

Үүнд:

- Шүүхээс сүүлийн 15 жилийн байдлаар шийдвэрлэсэн захиргааны зөрчлийг судлан үзвэл жилд дунджаар 10000-20000 орчим хэрэг шийдвэрлэдэг ба Монгол Улсын хэмжээнд жилд үйлдэгдэж буй зөрчлийн тоо улам өсөх хандлагатай байгаа нь иргэдийн архидан согтуурах, мансуурах бодисын хэрэглээ өссөн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд зөрчил, дутагдал тасрахгүй байгаатай холбож тайлбарлаж болох юм.

- Шүүхийн шийдвэрээр оногдуулсан баривчлах шийтгэлийг нийслэлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын харьяа “Баривчлах төв”, “Баривчлах байр”-д, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн

байгууллагын харьяа “Баривчлах байр”-д эдлүүлж байна. Аймаг, орон нутгийн хэмжээнд шүүхээс жилд дунджаар 200-400 орчим хүнд баривчлах шийтгэл оногдуулж байгаагаас Архангай, Өвөрхангай, Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Төв, Ховд зэрэг аймгуудад жил ирэх тусам өсч 400-1200 орчим хүнд баривчлах шийтгэл оногдуулж байна. Энэ нь аймгуудад өдөрт дунджаар 20-30, зарим аймгуудад 50-80 хүн баривчлагдах магадлалтай байна.

- Зөрчлийн тухай болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хүрээнд баривчлах шийтгэлийг зөвхөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гүйцэтгэх ба цаашид тухайн чиг үүргийг аймаг, орон нутгийн байдлаар хэрэгжүүлэхэд баривчлагдсан этгээдийг саатуулах байр, алба хаагч, удирдлагын тогтолцооны асуудал нэн шаардлагатай,

- Баривчлах төв нь баривчлагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сэтгэл зүйн, эрх зүйн, бясалгалын сургалтыг зохион байгуулж байна. Баривчлах байрны дотоод журамд зааснаар баривчлах төв /байр/ нь сургалтын танхимтай байх бөгөөд шүүхийн шийтгэвэрт заасан хугацаагаар албадан сургалтад хамруулна гэж заасан ба Баривчлах төв нь зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг үр дүнтэй зохион байгуулах зорилгоор 60-80 хүний багтаамжтай лекцийн заал, зөвлөгөө, тусламж үзүүлэх зориулалт бүхий өрөө тасалгааг орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр тоноглож сургалтын заал, танхимуудыг тохижуулсан нь чухал ач холбогдолтой ч хөтөлбөрийн агуулгыг өөрчлөх, мэргэжлийн багш, сургалтын байгууллагаар гүйцэтгүүлэн үр дүнг тооцдог тогтолцоонд шилжих шаардлага байна.

---o0o---

**ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ**

**CHARACTERISTICS OF LEGAL REGULATION OF EXECUTION OF
COURT DECISIONS IN SOME FOREIGN COUNTRIES
CASES**



Б.Батчимэг

Дотоод хэргийн их сургуулийн докторант

Товч утга: Энэхүү өгүүллээр гадаадын зарим орны шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бүтэц, тогтолцоо, үйл ажиллагааны онцлог, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлж буй сайн туршлагыг судалж, харьцуулан авч үзсэн болно.

Түлхүүр үг: захиргааны хэргийн шүүх, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, хувийн шийдвэр гүйцэтгэгч, шериф, маршалын алба, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

Abstract: This article examines and compares the structure, system, and operational characteristics of court decision enforcement organizations in some foreign countries, as well as the good practices of effective decision enforcement.

Keywords: Administration court, execution of court decisions in administrative case, court decision enforcement operation, sheriff, office of marshals, personal bailiff.

Улс орон бүрийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь өөрийн гэсэн механизмтай байдаг. Гэхдээ аль ч орны хувьд шүүхийн шийдвэрийг богино хугацаанд, үр дүнтэй гүйцэтгэхийг зорьдог бол ялгаатай тал нь уг зорилгод хүрэх арга замаар илэрдэг. Энэ талаар Б. Хесс “улс орны шүүхийн